



## ИХ БРИТАНИ УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Иргэний эрх зүйн маргаан)<sup>1</sup>

### ГАР УТАСНЫ UBER АППЛИКЕЙШНД БҮРТГЭЛТЭЙ ЖОЛООЧ НАРЫГ “АЖИЛТАН” ГЭЖ ҮЗНЭ

**САНАМЖ:** Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

**Шүүхийн шийдвэрийн дугаар:** UKSC/2019/0029

**Шүүхийн шийдвэрийн огноо:** 2021 оны 02 сарын 19-ний өдөр

**Шийдвэрийн төлөв:** Анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

### ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

“Uber BV” компани нь “Uber” аппликейшны технологийг эзэмшдэг Нидерландын Хаант Улсын компани бөгөөд “Uber London Ltd” компани нь Лондон хотод хувийн түрээсийн тээврийн хэрэгслийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй охин компани юм. Нэхэмжлэгч нар нь Лондон хотод хувийн түрээсийн тээврийн хэрэгсэл жолоодох зөвшөөрөлтэй, тус аппликейшныг идэвхтэй ашигладаг байсан жолооч нар бөгөөд тэд өөрсдийн хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн байдлыг тодорхойлуулах зорилгоор жолоочдыг хөдөлмөрийн хууль тогтоомжид заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доошгүй цалин авах, цалинтай ээлжийн амралт эдлэх болон бусад холбогдох эрхүүдийг эдлэх эрхтэй “ажилтан” мөн эсэхийг тодорхойлуулахаар “Uber London Ltd” компанийн эсрэг нэхэмжлэл гаргажээ.

Харин хариуцагч тал нь жолооч нарыг “Uber” аппликейшнаар дамжуулан үйлчлүүлэгчидтэй байгуулсан гэрээний дагуу ажилладаг бие даасан гэрээт гүйцэтгэгчид гэжээ. Ингэхдээ тээврийн хэрэгслийн үйлчилгээний төлбөрийг “Uber” аппликейшн тооцоолдог бөгөөд жолоочоос тус аппликейшн болон бусад үйлчилгээ ашигласны төлбөрийг хасаж тооцон, үлдэх хэсгийг жолоочид олгодог. Мөн жолооч нар ажлын цаг хамаарахгүйгээр буюу хүссэн хугацаандаа чөлөөтэй ажилладаг тул тэднийг хөдөлмөрийн хууль тогтоомжид заасан “ажилтан” гэх ангилалд хамаарахгүй хэмээн маргажээ.

### ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

**Хөдөлмөрийн шүүх:** ИБУИНХУ-д үйл ажиллагаа явуулж буй “Uber” аппликейшнд бүртгэлтэй жолооч нарын тоог 40,000 орчим гэж тооцоолсон бөгөөд үүнээс 30,000 орчим нь Лондон хотын бүсэд үйл ажиллагаа явуулж буй жолооч нар байна. [1996 оны Хөдөлмөр эрхлэгчдийн эрхийн тухай хуулийн 230 дугаар зүйлийн](#)

<sup>1</sup> Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: [https://supremecourt.uk/uploads/uksc\\_2019\\_0029\\_judgment\\_19c9de2253.pdf](https://supremecourt.uk/uploads/uksc_2019_0029_judgment_19c9de2253.pdf), Шүүхийн шийдвэрийг хураангуйлахдаа эх хувилбарын бүтцийг өөрчилсөн болно.



3 дахь хэсэг<sup>2</sup> болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан "ажилтан" гэх тодорхойлолт нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй этгээдийг хамардаг боловч хувиараа хөдөлмөр эрхэлдэг зарим хүмүүст ч мөн хамаарна. Улмаар нэхэмжлэл гаргасан жолооч нар нь энэхүү ангилалд хамаарах буюу тэд "Uber London Ltd" компанид хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байсан гэж Хөдөлмөрийн шүүх дүгнэжээ.

**Давж заалдах шатны шүүх:** Хөдөлмөрийн шүүх бодит нөхцөл байдлын үнэлгээг зөв хийсэн гэж үзэн жолооч нарын талд шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл, жолооч нарыг нэр төдий бие даасан "гэрээт гүйцэтгэгч" гэж бичсэнээс үл хамааран ажиллах харилцаа нь хөдөлмөрийн гэрээний харилцаа байсан гэж үзжээ. Тиймээс "Uber London Ltd" компанийн гаргасан давж заалдах шатны гомдлыг хэрэгсэхгүй болгож, Хөдөлмөрийн шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

**Улсын дээд шүүх:** "Uber London Ltd" компани нь жолоочийг зорчигчтой холбож зуучлах байдлаар ажилласан гэдэг нь үндэслэлгүй, харин зорчигчидтой гэрээ байгуулж, жолооч нарыг ажиллуулсан гэж үзэхээр байна. Мөн хувь хүнийг "ажилтан" гэж үзэх эсэхийг шийдвэрлэхдээ аль ч тохиолдолд гэрээг бичгээр байгуулсан эсэхээс үл хамааран Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн зорилгыг харгалзан үзэх шаардлагатай. Хөдөлмөрийн шүүх дараах үндэслэлүүдийг зөв тодорхойлсон хэмээн Улсын дээд шүүх тогтоолдоо дурджээ.

Тодруулбал, "Uber" аппликейшнаар захиалга хийгдэхэд төлбөрийг тухайн компани өөрөө тогтоодог байх бөгөөд жолооч зорчигчоос илүү төлбөр авах эрхгүй байгаа нь жолоочийн орлогыг "Uber London Ltd" компани тодорхойлдог гэж үзэх үндэслэлтэй. Мөн жолоочийн үйлчилгээ үзүүлэх гэрээний нөхцөлийг "Uber London Ltd" компани нэг талын шийдвэрээр тогтоодог буюу жолооч аппликейшнд нэвтэрсэн үед захиалгыг хүлээж авах эсэх сонголт нь "Uber London Ltd" компанийн бүрэн хяналтад байдаг. Захиалгаас олон удаа татгалзсан тохиолдолд жолоочийг автоматаар 10 минут аппликейшнаас гаргаж, ажиллах боломжийг нь хязгаарладаг байна.

Түүнчлэн жолоочийн үйлчилгээ үзүүлэх арга барилд ихээхэн хяналт тавьдаг буюу жолоочийн үнэлгээний системээр зорчигч бүр үйлчилгээний дараа жолоочийг 1–5 хүртэлх оноогоор үнэлдэг. Улмаар дундаж үнэлгээ нь шаардлага хангахгүй тохиолдолд жолоочид анхааруулга өгч, сайжраагүй тохиолдолд хамтын ажиллагааг дуусгавар болгодог байна. Иймд Хөдөлмөрийн шүүх эдгээр үндэслэлүүдийг харгалзан үзэж жолооч нарыг "ажилтан" гэж зөв тодорхойлсон байна.

---o0o---

<sup>2</sup> Employment Rights Act (1996), art. 230(3).